

Сэтгэцийн эмнэлгийн ажилтнуудын мэдээллийн хэрэгцээ, суралцах шаардлага

Грачева Т.Ю.¹, Шурыгина Ю.Ю.²

¹Кемеровын Анагаах ухааны академи, ЭХЯ, ОХУ

²Дорнод-Сибирийн технологи ба удирдлагын улсын их сургууль, Бурядын БНУ, ОХУ
e-mail: juliaju@mail.ru

Abstract**The need for information and training among staff of psychiatric clinics**

Gracheva T.Yu.¹, Shurygina Yu.Yu.²

¹Kemerovo State Medical Academy of the Ministry of Health, Russian Federation

²East-Siberian State University of Technology and Management, Republic of Buryatia, Russian
e-mail: juliaju@mail.ru

Background

Information and technology knowledge is important for the medical and non-medical staff of hospitals, regardless of their position.

Aim

To study needs for information and advanced training among medical professionals.

Material and Method

Using a survey questionnaire, the need for information of medical professionals, as well as the ability to independently receive and process the information received, was studied. Data was collected anonymously and obtained informed consent.

Results

A high need for up-to-date information among doctors was revealed; the willingness to work with information varied significantly depending on the age of the respondents. When assessing the possibility of satisfying the information, it was found that the available information support does not meet the modern requirements of medical workers in reference books and convenient mobile applications. The lack of commitment of doctors to the principles of evidence-based medicine, most often due to the difficulty in finding sources, was revealed. The possibilities of training doctors of different age groups are evaluated.

Conclusion

Organizational solutions are proposed to enhance the professional competencies of psychiatrists regarding the practical application of legislation.

Keywords: psychiatric clinic, the need for information, psychiatrists

Үндэслэл

Анагаах ухааны салбарт эрх зүйн зохицуулалтын үүрэг улам их өсөн нэмэгдэж байна [1, 2, 3]. Ялангуяа сэтгэцийн эмгэгтэй хүмүүст тусламж үзүүлэхэд хууль эрх зүйн зохицуулалтууд ихээхэн хэрэглэгддэг [4, 5]. Энэхүү зохицуулалтууд шаардагдах тохиолдлуудыг дурьдвал: Эмнэлгийн үзлэг хийхэд таниулсан сайн дурын зөвшөөрөл авах, гэрчийг байлцуулах, эмнэлэгт хэвтүүлж эмчлэх, сэтгэцийн эмгэгтэй хүний эрхийг хангах, үйлдэл хийх чадвар алдах, өөрийнх нь зөвшөөрөлгүйгээр эмнэлэгт хэвтүүлэх ба гэрчийг байлцуулах, албадан эмчилгээнд хамруулах зэрэг [6] бусад асуудлууд байдаг. Практик үйл ажиллагаандаа шинэлэг эрх зүйн хэм хэмжээний актуудыг тухай бүр танилцаж ашиглах асуудал нь ажилтнуудад өсөн нэмэгдэж байгаа ачааллаас хамаарч хүндрэлтэй байдаг [7, 8, 9].

Зорилго

Сэтгэцийн тусламжийн зохицуулалтыг хангаж буй хууль эрх зүйн хэм хэмжээний хүрээнд сэтгэцийн эмч нарын бие даан суралцах боломжийг судлахыг зорив. Энэ ажлын үр дүнд сэтгэцийн эмч нарыг бие даан сургах, эмч нарын үйл ажиллагааны эрх зүйн хэм хэмжээг бий болгох саналуудыг боловсруулах юм.

Материал, арга зүй

Эрх зүйн мэдээллийн хэрэгцээг судлах зорилгоор төгсөлтийн дараах сургалтын тэнхимд 2009-2019 онд хяналт эмнэлгийн эрх зүйн чиглэлээр сургалтад хамрагдаж байсан эмнэлгийн ажилтнуудын бүлгээс сонгов. Судалгааг Т.В. Андреева (2003)-ийн арга зүйн дагуу гүйцэтгэв [10]. Асуулгад Кемерово мужийн сэтгэцийн тусламж үзүүлдэг Кемерово, Новокузнецк, Прокопьевск, Ленинск-Кузнецкий, Анжеро-Судженск, Калтан, Белово, Юрга, Междуреченск, Киселёвскийн 10 эмнэлгийн байгууллагад ажилладаг 863 хүнийг хамруулсан. Асуулгыг нэргүйгээр, эмнэлгийн үзлэгийн үеэр эмнэлгийн бусад ажилтнуудын жагсаалтаас оролцогчийг сонгож, явуулав. Хоёр дахь (харьцуулах) бүлэгт 216 дотрын эмч, нийгмийн ажилтнуудыг хамруулсан байна. Харьцуулах бүлэгт оролцогчийг ажил мэргэжлийн төсөөтэй байдал, ойролцоо ур чадвар зэргээр сонгосон ба үүнд сэтгэцийн эмч нарын эрх зүйн талаарх давуу ур чадварыг харгалзан үзээгүй. Оролцогчдоос таниулсан зөвшөөрлийг авсан. Оролцогчдын бүлэг нь нийт эмнэлгийн ажилтнууд, тэдний нас, хүйсний харьцааг төлөөлж байгаа юм. Асуулгад мэдээллийн хэрэгцээ, мэдээллийн хэрэгцээг

хангах, мэдээллийн хангалт, мэдээлэлтэй ажиллах боломж зэрэг бүлэг асуултуудыг багтаасан.

Үр дүн

Сэтгэцийн тусламж үзүүлдэг эмнэлгийн байгууллагын ажлын нөхцөл стресс ихтэйг [1, 4, 10] харгалзан эмнэлгийн болон эмнэлгийн бус ажилтнуудын эрх зүйн мэдлэг, мэдээллийн хэрэгцээ, мэдээлэлтэй ажиллах боломжийг судлах нь чухал бөгөөд шаардлагатай байна. Асуулгад [9,6% (7,8–11,8)] нь янз бүрийн түвшингийн эмнэлгийн байгууллагын удирдах ажилтнууд, [42,3% (39,0–45,6)] нь эмч нар, [30,8% (27,8–34,0)] нь сувилагч нар болон [17,3% (14,9–19,9)] нь эмнэлгийн бус ажилтнууд хамрагдсан. Мэргэжлээрээ эмнэлгийн байгууллагад 5 хүртэл жил, 6-10 болон 11-15 жил ажилласан нь нийт оролцогчдын 11,9% (9,9–14,3) болон 24,6% (21,8–27,6) байхад, 16-20 жил ажилласан нь [17,9% (15,5–20,7)], 21 ба түүнээс дээш жил ажилласан нь 21,0% (18,4–23,8) байна.

Оролцогчдын 18,9% (16,4–21,6) нь 30 хүртэлх насны, 32,2% (29,2–35,4) нь 31-40 насны 22,4% (19,7–25,3) нь 41-50 насны байсан бол 26,5% (23,7–29,6) нь 51 ба түүнээс дээш насны хүмүүс эзэлж байв.

Мэргэшлийн туршлагатай, хөдөлмөрийн идэвхитэй насанд байгаа, өөрөөр хэлбэл салбартаа хамгийн үр ашигтай ажиллаж буй боловсон хүчинд мэдээллийн технологийн мэдлэг хэрэгцээ шаардлагатай байна. Тухайлбал, мэдээллийн мэдлэгийн хэрэгцээг судлахдаа судлаач нь асуулгад оролцогчдоос мэргэжлийн үйл ажиллагаандаа мэдээллийн технологийн шаардлага байгаа эсэх талаар лавлахад зөвхөн 5,4% (4,1–7,2) нь цахимжуулах шаардлагагүй гэж үзжээ. Эдгээр нь сувилагч байсан (17,7% (13,6–22,7) ба удирдлага, эмч, эмнэлгийн бус ажилтнуудаас ийм хариулт өгөөгүй байна.

“Мэдээллийн хэрэгцээ” гэх бүлэг асуултаар мэдээллийн шаардлага байгаа эсэх болон түүний шинжийг тодруулав. Асуулгад оролцсон 864 хүнээс ердөө 2,3% (1,5–3, 6) нь лавлагаа мэдээлэл шаардлагагүй гэсэн ба эдгээрийн 3,0% (1,5–5,8) нь эмнэлгийн сувилагч нар, 8,8% (5,1–14,7) нь эмнэлгийн бус ажилтнууд байна. Бусад хариулагчдын 3,6% (2,5–5,0) нь сард 1-ээс бага удаа, 16,7% (14,4–19,4) нь сард 1 удаа, 33,1% (30,0–36,4) нь долоо хоногт 1 удаа гэж үзсэн бол 46,6% (43,3–50,0) нь долоо хоногт 1-ээс олон удаа мэдээлэл авах шаардлагатай буюу

тэдний бараг тал хувь нь лавлагаа мэдээлэл өдөр тутам хэрэгтэй гэж хариулсан байна. “Ямар төрлийн мэдээлэл авах сонирхолтой вэ?” гэсэн асуултад олон сонголттойгоор дараах хариултыг өгсөн байна. Үүнд эрүүл мэндийн мэдээллийг 77,7% (74,8-80,4); хууль эрх зүйн хэм хэмжээний холбогдолтой (хууль, хууль эрх зүйн актууд) мэдээллийг 67,4%; лавлах мэдээллийг (стандарт, хөнгөлөлт, эмийн болон бусад) 75,9% (72,9-78,7); ОХУ-ын Эрүүлийг хамгаалах яамны тушаалуудыг 91,2% (80,1-92,9); сэтгэцийн эрүүл мэндийн үйлчилгээний холбоотой тушаал, журмыг 81,0% (78,2-83,5); хууль эрх зүйн мэдээллийг 89,1% (86,8-91,0); эдийн засгийн мэдээллийг 83,4% (80,7-85,8); байгууллагын боловсон хүчний асуудал, нөөцийн талаарх мэдээллийг 84,8% (82,2-87,1) нь тус тус сонгон хариулжээ. Эндээс харахад төрөл бүрийн мэдээллийн хэрэгцээ их байгаа ба (ихэнхдээ эдгээр нь эрүүл мэндийн, эрх зүйн болон эдийн засгийн мэдээлэл) энэ хэрэгцээг хангахад мэдээллийн шинэ технологигүйгээр шийдвэрлэх боломжгүй юм.

Сүлжээний цахим программууд ашигладаг эмнэлгийн байгууллагуудад сүүлийн 5 жилийн хугацаандажилласанажилтнуудаасмэдээллийн хэрэгцээг хангаж байгаа түвшинг тодруулахад тэдний 7,9% (6,3-9,9) нь «хангалтгүй», 39,0% (35,8-42,4) нь «50,0%-аас бага» гэсэн үнэлгээг, 28,2% (25,3-31,4) нь «50%-аас их», 24,8%(21,9- 27,8) нь «бүрэн хангалттай» гэж хариулсан. Хэрэглэгчдийн саналыг үндэслэвэл, ажиллагсадад зориулагдсан лавлах мэдээлэл хангалтгүй, мөн мэдээллийн эрэлт хэрэгцээ

улам бүр нэмэгдэж байгааг дээрх байдал харуулж байна.

Мэдээллийн хэрэгцээг хангах боломжийг үнэлэхэд оролцогчдын 95,1% (93,5-96,4) нь ажилдаа компьютер ашигладаг.Тэдгээрийн 91,8% (89,8-93,4) нь гэртээ компьютертэй ба 69,3% (66,0-72,4) нь гэртээ компьютер дээрээ ажилладаг байна. Нийт ажиллагсадын 53,4% (49,9-56,8) гэрийн цахим хаягтай байв.

Мэдээллийн хэрэгцээ шаардлагын үнэлгээг судлан үзэхдээ мэдээлэл оруулах үйлдлээс мэдээллийн боловсруулалтын программ хангамж хэрэглэх, мэдээллийн бааз бий болгох хүртэл үйлдлүүдийн түвшинг хамруулсан байна. Асуулгад оролцогчдын талаас илүү буюу 52,8% (49,5-56,2) нь, үүний дотор удирдлага, эмч нарын [39,5% (36,3-42,8)] мэдээллийг боловсруулах шаардлагатай гэж 27,8 % (24,9-30,9) нь, 25,0% (22,3-28,0) нь статистикийн дүгнэлтүүдийг авах хүсэлттэй гэдгээ илэрхийлжээ. Эмнэлгийн ажилтнуудын 65,8% (62,6-68,9) нь мэргэжлийн үйл ажиллагаа нь мэдээлэлд ерөнхий байдлаар хандах байдлаар хязгаарлагдахгүй гэсэн байна. Нийт оролцогчдын 82,9% (80,2-85,2) нь компьютер дээр [бүлэг хэсгээрээ гэж 79,3% (66,6-88,0) ба түүнээс дээш] ажиллах замаар мэргэжлийн асуудлаа гүнзгий судлана гэж хариулжээ. Мөн эмнэлгийн дунд мэргэжлийн ажилтнууд ч дан ганц механик үйл ажиллагаа хийдэггүй байна.

“Ажилдаа компьютер хэр их ашигладаг вэ” гэх асуултын олон сонголтот хариултыг 1-р хүснэгтээр харуулав.

Table 1. Degree of computer use at work

Skill level of computer use	Managers		Physicians		Midlevel medical professionals		Nonmedical professionals	
	%	95% CI	%	95% CI	%	95% CI	%	95% CI
Data entry	88,0	79,2 - 93,3	92,1	88,8 - 94,4	75,6	70,1 - 80,3	84,6	77,0 - 89,5
Data processing	95,2	88,3 - 98,1	72,3	67,5 - 76,7	77,8	72,5 - 82,4	62,4	54,4 - 69,8
Information receiving	90,4	82,1 - 95,0	65,8	60,7 - 70,4	86,5	81,8 - 90,1	53	45,0 - 60,9
Data analysis	100,0	95,6 - 100,0	76,7	72,1 - 80,8	58,7	52,7 - 64,4	76,5	69,1 - 82,6
Data based forecasting	100,0	95,6 - 100,0	45,2	40,2 - 50,3	12,8	9,3 - 17,3	81,2	74,2 - 86,7

Компьютерын мэдлэгийг ямар хэлбэрээр олж авсан талаархи асуултанд оролцогчдын 6,7% (5,2-8,6) хайхрамжгүй хандаж хариулагчдын хэсэг бүлгүүдийн хооронд статистикийн ялгаа илрээгүй (удирдлага-0,0% (0,0-6,8), эмч нар -8,8% (6,5-11,9), сувилагч нар-5,2% (3,0-8,9),

эмнэлгийн бус ажиллагсад-5,3% (2,8-0,2). Оролцогчдын дийлэнх буюу 75,9% (72,9-78,6) нь сургалт зайлшгүй шаардлагатай гэж үзсэн бол 17,4% (15,0-20,1) нь заавал биш гэж хариулжээ.

Компьютерийг шаардлагатай түвшинд эзэмшсэн байх талаар үнэлэхдээ 82,9% (80,3 – 85,3) бүгд жигд ижил түвшинд эзэмшсэн байх нь зүйтэй гэж үзжээ. Тухайлбал, удирдлагын 84,9% (73,0–92,1) нь, эмч нарын 85,2% (81,5–88,2) нь, эмнэлгийн дунд мэргэжлийн ажилтнуудын 81,2% (75,7–85,8) нь, эмнэлгийн бус ажилтнуудын 78,5% (71,3–84,4) нь дээрх байдлаар хариулсан ба тэдний хооронд статистикийн ялгаагүй байв. Асуулгад хамрагдсан цөөн хүмүүс “мэргэшлийн төрөл, ажиллагаанаас хамаарч компьютер эзэмшсэн байдал харилцан адилгүй байж болно” гэж үзсэн байна.

Нотолгоонд суурилсан анагаах ухаан болон интернет дэх эмнэлгийн сайтууд дээр ажиллах асуултанд дараах байдлаар хариулсан байна. “Нотолгоонд суурилсан анагаах ухаан” гэж юу вэ гэдэгт 58,6% (55,3–61,9) хариулсан ба тэдний хооронд статистик магадлал бүхий ялгаатай байв. Жишээлбэл, удирдлагын 90,6% (79,8 – 95,9), эмч нарын 68,3% (63,8–72,5), сувилагч нарын 45,4% (39,1–51,9), эмнэлгийн бус ажиллагсадын 39,6% (32,1–47,6) нь мэднэ гэж хариулжээ. “Нотолгоонд суурилсан анагаах ухаан” гэдгийг мэднэ гэсэн хариулагчдын 74,9% (70,9–78,5) нь анагаахын мэдээллийг эрэн хайхдаа эмнэлгийн нотолгоо гаргах зарчмуудыг баримталдаг байна. Эдгээр бүлэг хоорондын хариултанд статистикийн ач холбогдол бүхий ялгаа илрээгүй байна. Тухайлбал, удирдлагын 80,3% (70,0–87,7) нь, эмч нарын 74,1% (68,3–79,2), сувилагч нарын 75,0% (66,7–81,8), эмнэлгийн бус ажилтнуудын 71,2% (58,6 – 81,2) нь юм.

Анагаах ухааны нотолгооны зарчмуудын судлах хэрэгцээг илрүүлэхэд нийт оролцогчдын 23,3% (20,6–26,2)-д ийм шаардлага байхгүй гэсэн хариултыг авсан байна. Тавигдсан асуултад сөрөг хариулт өгсөн оролцогчдын бүлэг хооронд хариулт дараах байдалтай байна: Удирдлагын 23,3% (20,6–26,2), эмч нарын 26,0% (21,8–30,8), сувилагч нарын 11,3% (8,0–15,7), эмнэлгийн бус ажилтнуудын 20,1% (14,5–27,3) эмнэлгийн нотолгоо гаргах зарчмуудыг судлах шаардлагагүй гэж хариулжээ.

Хэлцэмж

Сэтгэцийн эмнэлгүүдийн эмнэлгийн болон эмнэлгийн бус ажилтнуудад албан тушаалаас үл хамаарч мэргэжлийн ажилд нь мэдээллийн болон технологийн мэдлэг чухал ач холбогдолтой гэж үзэж байна. Бүх оролцогчдоос удирдлагын ажилтнууд мэдээллийн технологийг эзэмшин ажилдаа хэрэглэдэг ба компьютержүүлэх

нөхцөлд боловсруулах, дүгнэх ажилд анхаарлаа хандуулж, мэдээлэлжүүлэх үйл явцад бүх бүлгүүдийн ажилтнуудад оролцох шаардлага тавьдаг байна. Ажил дээр компьютер ашиглахад гэрийн мэдээллийн хэрэгсэл дөхөм үзүүлж байгаа ба персонал компьютер нь өдөрт тутмын хэрэгцээ юм. Эмч нарын мэргэжлийн үйл ажиллагаанд компьютер ашиглаж байгаа нь удирдлагын түвшнээс арай хязгаарлагдмал байна. Эмч нар мэдээллийн технологитой ажиллах ажиллагаанд мэдээллийг шивэх ажилд эмнэлгийн дунд мэргэжилтэн ажилтнуудын оролцоо арай илүү гэж үзэж байна. Сувилагч нар шинэлэг зүйлийг мэдэх тэмүүлэлтэй, мэдээллийг шивж оруулах ажлыг механик ажил гэж тооцдоггүй байна. Эмнэлгийн дунд мэргэжлийн ажилтнуудад өөрийн нөөц боломжоороо компьютер болон мэдээллийн технологийг эзэмших нөхцөл ижил, компьютерийн программ хангамжуудтай ажиллахдаа логик сэтгэх зорилго тэмүүлэлтэй байна.

Боловсон хүчний хууль эрх зүйн сургалтыг явуулахдаа эмнэлгийн болон эмнэлгийн бус ажилтнуудын албан тушаалын онцлогийг харгалзан үзэх нь зүйтэй.

Сэтгэцийн эрүүл мэндийн байгууллагуудад хууль эрх зүйн үйлчилгээг зохион байгуулах, үүний дотор лавлагаа мэдээллийн системийг ажиллуулах санал болон “хүчээр эмнэлэгт хэвтүүлэх”, “эмчилгээний чиглэлээр авах албадлагын арга хэмжээнүүд”, “шүүх-сэтгэцийн экспертүүдийн дүгнэлтийг няцаах”, “үйлдлийн чадвар алдах” зэрэг хэсгүүдээр шүүхийн шийдвэрүүдийг танилцуулсан. Энэ бүхэн нь ажиллагсдад төдийгүй суралцагчдад ач холбогдолтой юм [11,12,13].

Дүгнэлт:

Орчин үед нэг талаас мэргэжилтнүүдийн эрх зүйн мэдлэгийн хангалттай бус түвшин, нөгөө талаас эрүүл мэндийн салбарт хууль эрх зүйн чиглэлийн мэдээллийн технологийг өндөр түвшинд эзэмшсэн мэргэжилтнүүдийн өсөн нэмэгдэж байгаа шаардлага хооронд байгаа үл нийцлийг даван туулах нөхцөл боломжийг эрэн хайх нь чухал болж байна.

Талархал

Өгүүллийг орос хэлнээс монгол хэлнээ орчуулсан АШУҮИС-ийн Нийгмийн эрүүл мэндийн сургуулийн багш, дэд профессор М.Сугармаад талархлаа илэрхийлье.

Ном зүй

1. Арабули Д.Т. Гарантии прав подозреваемого и обвиняемого при назначении и производстве судебно-психиатрической экспертизы. Вестник Оренбургского государственного университета. 2008. № 3 (84). с.24-29.
2. Ржевская Н.К., Руженков В.А. Законодательство о применении мер физического стеснения при оказании психиатрической помощи. Научные ведомости Белгородского государственного университета. Серия: Медицина. Формация. 2014. № 24(195). с.103-111
3. Тараканова Е.А. Психиатрия и правовое законодательство. Бюллетень медицинских интернет-конференций. 2012. Т. 2. № 11. с.891.
4. Андреева Т.В. Новые педагогические подходы в обучении работников здравоохранения основам информатики. Диссертация на соискание уч.степ. канд.пед.наук/Российская медицинская академия последипломного образования. Москва, 2003. с.158
5. Носачев Г.Н. Дефицит институционального общения как одна из причин кризиса психиатрии. Социальная и клиническая психиатрия. 2019. Т. 29. № 1. с.73-78.
6. Москвичев В.Г. Практические и этические аспекты использования мер физического стеснения пациентов при оказании им медицинской помощи // Амбулаторный прием. 2016. Т. 2. № 3 (6). с.78-81.
7. Жигинас Н.В. Новые научно-организационные формы медико-психологического сопровождения учебного процесса в вузе. Сибирский вестник психиатрии и наркологии. 2011. № 3. с.93-97.
8. Куприянова И.Е., Бохан Н.А., Лебедева В.Ф. Психическое здоровье населения в евразийском регионе (по материалам XVI конгресса ВПА). Сибирский вестник психиатрии и наркологии. 2014. № 4 (85). с.102-104.
9. Стоянова И.Я., Семке В.Я., Филоненко А.Л. Динамика стрессоустойчивости во время экзаменационной сессии у студентов. Сибирский вестник психиатрии и наркологии. 2013, № 1, с.75-77.
10. Андреева Т.В. Новые педагогические подходы в обучении работников здравоохранения основам информатики. Диссертация на соискание уч. степ. канд. пед. наук. Российская медицинская академия последипломного образования. Москва, 2003. с.158
11. Парашенко А., Яковлев Е., Тяхт И. Амбулаторная судебно-психиатрическая экспертиза несовершеннолетних // Медицина: целевые проекты. 2018. № 31. с.30-31
12. Протокол ведения больных: судебно-психиатрическая экспертиза // Проблемы стандартизации в здравоохранении. 2005. № 8. с.26-74
13. Аксенов М. М. и др. Стрессоустойчивость и дезадаптация при непсихотических психических расстройствах (итоги комплексной темы НИР ФГБУ «НИИПЗ» СО РАМН, 2009-2012 гг.)/Сибирский вестник психиатрии и наркологии. 2013, № 4. с. 11-18

Танилцаж, нийтлэх санал өгсөн:

*Анагаах ухааны доктор, профессор
Л.Насанцэнгэл*